



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/3021

Мандалговь

Эрх шилжүүлэн ажил
гүйцэтгүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр аймгийн ИТХ-ийн 2017 оны 12 дүгээр сарын 4 ны өдрийн 25 дүгээр тогтоолоор батлагдсан "Дэлгэрцогт, Өндөршил сумдын ЗДТГ-ын хэрэгцээнд автомашин"-ын ажлын эрхийг Дэлгэрцогт, Өндөршил сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

Хоёр. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, шууд гэрээ байгуулан, ажлыг чанартай гүйцэтгүүлж, үе шатны ажилд тавьж, холбогдох бичиг баримтыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлэхийг Дэлгэрцогт сумын Засаг дарга (Б. Иш-Ёндон), Өндөршил сумын Засаг дарга (Л. Мөнхбадрах)-д үүрэг болгосугай.

Гурав. Худалдан авах ажиллагааны болон гүйцэтгэлийн бичиг баримтын бүрдлийг хянаж, журмын дагуу санхүүжилт хийхийг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Санхүү төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

409010043